



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 101

Номгон

Монгол Улсын “Гавъяат” цол,  
Төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах  
хүмүүсийн тодорхойлолт өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН “ХҮНИЙ ГАВЪЯАТ ЭМЧ” ЦОЛООР

1.Цэрэн-Очирын Эрдэнэцэцэг Богд сумын Сум дундын эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн эмч

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ГООР

1. Дэнсмаагийн Энэбиш Нэгдсэн эмнэлгийн дотрын эмч

“АЛТАН ГАДАС ОДОН”-ГООР

- |                          |   |
|--------------------------|---|
| 1.Сүхцэрэнгийн Маам      | Богд сумын Сум дундын эмнэлгийн багийн эмч        |
| 2.Бямбаагийн Амаа        | Баянхонгор сумын ахмад настан                     |
| 3.Цэвээнбалын Сосорбарам | Бургатай хувийн эмнэлгийн захирал, их эмч         |
| 4.Загдын Баасанхүү       | Эрүүл мэндийн газрын статистикч бага эмч          |
| 5.Чагнаадоржийн Баяр     | Баянхонгор сумын иргэн                            |
| 6.Омбоогийн Сэр-Од       | Баянхонгор сумын ахмад настан                     |
| 7.Болдын Болормаа        | Эрүүл мэндийн газрын статистикч бага эмч          |
| 8.Нэргүйн Амараа         | Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн                  |
| 9.Гончигийн Тогоо        | Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч     |
| 10.Гэндэнжавын Дарьсүрэн | Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дүн бүртгэгч |
| 11.Самбуугийн Доржсүрэн  | Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн машинист     |
| 12.Равдангийн Цэдэвсүрэн | Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн тогооч       |

116977

- |  |   |
|--|---|
| 13.Бямбаагийн Пүрэвсүрэн<br>вакцинатор | Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн            |
| 14.Баатарын Одонтуяа<br>эмч            | Богд сумын Сум дундын эмнэлгийн эх баригч, бага |
| 15.Маахүүгийн Алтанцэцэг<br>эрхлэгч    | Богд сумын Сум дундын эмнэлгийн эмийн сангийн   |
| 16.Авирмэдийн Пагмадулам               | Богд сумын Сум дундын эмнэлгийн багийн эмч      |
| 17.Намхайжанцангийн Энхжаргал          | Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн                |
| 18.Бальдарын Нямцэрэн                  | Богд сумын Сум дундын эмнэлгийн багийн бага эмч |
| 19.Самданхоролын Юмчигмаа              | Богд сумын Сум дундын эмнэлгийн багийн бага эмч |
| 20.Дашдуламын Цогзолмаа<br>сувилагч    | Богд сумын Сум дундын эмнэлгийн ариутгагч,      |
| 21.Лодойдамбын Ганцэцэг                | Богд сумын Сум дундын эмнэлгийн үйлчлэгч        |
| 22. Данзангийн Амгалан                 | Шинэжинст сумын ахмад настан                    |
| 23.Дамчаабадгарын Баярмагнай           | Баянхонгор иргэний нисэх буудлын машинист       |

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 102

Номгон

"Баянхонгор-Эрчим хүч" ХХК-ний  
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ний дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч А.Тарва, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Э.Гүнжинлхам нарыг нэмж оруулсугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116079



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 102

Номгон

“Чандмань-Баянхонгор” ХК-ний  
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Компаний тухай хуулийн 62.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Чандмань-Баянхонгор” ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Т.Очирбал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Д.Идэрханд нарыг нэмж оруулсугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 104

Номгон

“Цэвэр хот” ХХК-ний Төлөөлөн  
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Цэвэр хот” ХХК-ний дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Цэвэр хот” ХХК-ний төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ж.Дулмаа, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Д.Цэрэнхорлоо нарыг нэмж оруулсугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116973



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 105

Номгон

Хөрөнгийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6 нэрийн 66498414.11 төгрөгийн актлах хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 05-07-020/61 дугаар бүхий актаар Түүх угсаатны зүй-Байгалийн музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2006 онд ашиглалтад орсон 9438591 төгрөгийн өртөгтэй элэгдлээ 100 хувь нөхсөн нам даралтын бага оврын уурын зуухыг ашиглах боломжгүй гэж тогтоосон тул акталж тус тус данснаас хассугай.

2. Хөх толгойн ШС6,3 квт шугамын шонгийн 21 ширхэг модыг “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний эргэлтийн хөрөнгөд орлого авч бүртгэсүгэй.

3. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК, Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй граж, автомашинуудын худалдах доод үнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. Автомашин, гражийн барилгын дуудлага худалдааг 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж орлогыг “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ний Хаан банкны 5225031153 тоот дансанд, Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын автомашины үнийг Төрийн сан банкин дахь Орон нутгийн өмчийн газрын 030051006 тоот дансанд тус тус төвлөрүүлсүгэй.

5. Орлого авсан, акталсан, худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116087

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны  
105 тогтоолын нэгдүгээр хавсралт

БАЯНХОНГОР ЭРЧИМ ХҮЧ ЦТ ХХК-НЫ АКТЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг	Тайлбар
1	Баянхонгор	Эрчим хүч ЦТ ХХК	Үндсэн бетон хашаа	2001.03.07	1	2366000.00	2366000.00	2352977.56	13022.44	Хашааг шинэчлэн солисон ашиглах боломжгүй
2	Баянхонгор	Эрчим хүч ЦТ ХХК	Хөх толгойн ШС 6.3	1998.01.01	4,700	9260.77	43525619.00	43525619.00	0.00	Шугамын модон тулгуурыг шинэчилэн бетон тулгууртай болгосон бөгөөд 21 ширхэг шонгийн модыг буулган хүлээн авсан
3	Баянхонгор	Эрчим хүч ЦТ ХХК	Халаалтын тогоо/	2008.04.03	1	3597700.00	3597700.00	3099948.22	497751.78	Шатсан ашиглах боломжгүй болсон
4	Баянхонгор	Эрчим хүч ЦТ ХХК	Хашааны төмөр хайс	2006.05.31	300	25195.86	7558758.00	7558758.00	0.00	Байгууллагын хашааг шинэчлэн солисон буулгаж авсан
5	Баянхонгор	Эрчим хүч ЦТ ХХК	Байгууллагын гэрлэн хаяг	2009.07.09	1	3730846.95	3730846.95	3730846.95	0.00	Байгууллагын хаягийг шинэчлэн солисон
6	Баянхонгор	Эрчим хүч ЦТ ХХК	Гадна гэрэлтүүлэг	2003.05.26	1	5719490.16	5719490.16	5719490.16	0.00	Хуучин гэрэлтүүлгийг шинэчлэн солисон буулгаж авсан.
							66498414.11	65987639.89	510774.22	

ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Ашиглагч тад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Дуудлагаар худалдах доод үнэ	Тайлбар
					сери	дугаар		арлын дугаар	моторын дугаар	моторын эзлэхүүн /см <sup>3</sup> /		
1	Баянхонгор	"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	1 машины граж		м2	22.5	2003.04.18				630,000.00	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй
2	Баянхонгор	"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	Авто-кран Зил-130	КС-2561	БНА	14-56	2005.03.17	2420042	513615	4254	4,045,342.05	Сүүлийн 3 жилд засвар хийсэн бөгөөд одоо байгаа үлдэх өртөг
3	Баянхонгор	"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	ISUZU ТРАК ачааны авто кран	isuzu elf	УБР	12-80	2003	PR66P7405059	200063	3100	3,361,672.00	Сүүлийн 3 жилд засвар хийсэн бөгөөд одоо байгаа үлдэх өртөг
4	Баянхонгор	"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	ISUZU фикап ачааны автомашин	ISUZU фикап	БНА	39-81	2003.02.11	55417103031	801298	2711	2,000,000.00	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй үлдэгдэл өртөггүй
5	Баянхонгор	"Баянхонгор эрчим хүч" ЦТХХК	HYUDAI YERNA суудлын авто машин	HYUDAI YERNA	БНА	97-01	2010.03.06	КМНСG41FP1U 245450	10406	1300	800,000.00	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй
6	Баянговь сум	ЗДТГ	Суудлын автомашин пургои	УАЗ-220692	БНА	25-45	2011.02.25	101904 36790	0005223	D2890	1,390,000.00	2011 онд 20.0 сая төгрөгөөр худалдан авсан үлдэгдэл өртөг 1388888 төгрөг
			<b>Дүн</b>								13027014.1	





БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 106

Номгон

Орон нутгийн өмчийн алба байгуулсан  
68 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Орон нутгийн өмчийн газрыг хэрэгжүүлэгч агентлагаар ажиллуулахаар тогтоосон тул Орон нутгийн өмчийн албыг байгуулсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 68 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Орон нутгийн өмчийн эд хөрөнгөтэй холбогдон гарсан журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 107

Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 40 дүгээр тогтоолыг  
хүчингүй болгох тухай

Баян-Ойт цогцолбор сургуулийн 2016 оны 124 дүгээр албан тоотор ирүүлсэн саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Нийтийн номын сангийн хуучин барилгыг “Баян-Ойт” цогцолбор сургуульд шилжүүлсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 40 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 108

Номгон

Цагдаагийн ахлах ахлагч Б.Төмөрсүхэд  
орон сууцны үнийн хөнгөлөлт үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3а, б, Цагдаагийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын Номгон 1 дүгээр баг хариуцсан цагдаа ажилтай. Цагдаагийн ахлах ахлагч Б.Төмөрсүх нь цагдаагийн байгууллагад 10 жил ажилласан өрх толгойлсон эмэгтэй бөгөөд худалдан авсан орон сууцны үнээс 7142480 /долоон сая нэг зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун наян/ төгрөгийг чөлөөлсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 109

Номгон

Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны  
пургон автомашинд эзэмшигч тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам"-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ус, цаг уур, орчны шинжилгээний алба нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр УАЗ 220695F0477509 маркийн 50-08БНХ улсын дугаартай пургон автомашиныг 23600000 төгрөгөөр худалдан авсан тул хөрөнгийн эзэмшигчээр Орон нутгийн өмчийн газрыг тогтоосугай.

2. Ус, цаг уур, орчны шинжилгээний албатай автомашин ашиглуулах гэрээ байгуулж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116096



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 111

Номгон

“Монголболгаргео” ХХК-ний үйл  
ажиллагааг зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Монгол, Болгарын хамтарсан Монголболгаргео төрийн өмчит компаний үйл ажиллагааг “Монголболгаргео” ХХК, “Жинлиань” ХХК хоорондын маргаан шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд зогсоосугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116075



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 112

Номгон

Аймгийн хаалга, сүлд шалгаруулах  
уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хаалга, сүлд шалгаруулах уралдааныг 2016 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны хугацаанд зарласугай.
2. Аймгийн хаалга, сүлд шалгаруулах уралдааны болзлыг хавсралтаар баталсугай.
3. Аймгийн хаалга, сүлд шалгаруулах уралдааны шагналын санд шаардагдах 2000000 /хоёр сая/ төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс гаргахыг нягтлан бодогч /Г.Ариунбаяр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

АЙМГИЙН ХААЛГА, СҮЛД  
ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ БОЛЗОЛ

Нэг. Зорилго

1.1 Аймгийн төвөөс Улаанбаатар чиглэлийн төв замын дагуу байрлах хаалга, сүлдийг шинэчлэн бүтээх нь Баянхонгорчууд аймгийнхаа хаалга, сүлдний утга агуулгыг мэддэг, тэр утгаараа үр, хүүхэд хойч үедээ бага наснаас нь ойлгуулж, хүн бүр дээдлэн шүтэж, биширч, бахархаж явдаг байх агуулгаар хаалга, сүлд нь бүтээгдсэн олон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар баталж зохих журмын дагуу хүндэтгэлтэй байршуулах зорилго тавьсан болно.

Хоёр. Уралдаанд ирүүлэх бүтээлүүдэд тавигдах шаардлага

2.1 Аймгийн хаалга, сүлд нь Баянхонгор аймгийн газар нутгийн онцлог, уул, ус, түүх, өв соёл, дурсгалт газрыг илэрхийлж чадахуйц энгийн ойлгомжтой, төрийн үйл ариун бадрахын утгыг бэлэгшээж илэрхийлсэн агуулга, өнгө зохицлын уялдаатай утга санааг илэрхийлсэн байх

2.2 Уралдааныг мэргэжлийн дизайнер, зураач, урчууд, сонирхогчид оролцонс.

2.3 Хаалга, сүлдний зургийг 3 талаас нь А3 формат дээр зурна. Мөн 3D хэлбэрийн баримал 1 ширхэг байна.

2.4 Уралдаанд нэг уран бүтээлч хэдэн ч дизайны шийдэлтэйгээр оролцож болох бөгөөд бүтээл тус бүрийг тайлбарласан текстийг хавсаргана.

Гурав. Шагнал урамшуулал, шалгаруулах хугацаа

3.1 Өргөмжлөл, мөнгөн шагнал - хаалга, сүлд тус бүр 1000000 /нэг сая төгрөг/ олгоно.

3.2 Уралдаанд ирүүлэх бүтээлүүдийг 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хүлээн авах бөгөөд зөвхөн нэг бүтээлийг шалгаруулна.

3.3 Бүтээлийг хүлээн авснаас хойш томилогдсон ажлын хэсэг шилдэг бүтээлүүдийг шалгаруулж, шалгарсан бүтээлүүдээр 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр үзэсгэлэн гаргана.

Зөвлөмж: Өндөр гэгээн Г.Занабазар аливаа бэлэгдлийн бүтээл нь

Ухахуйяа утга гүн

Дүрслэхүйеэ амар хялбар

Үзэхүйеэ дүрс билгүүн хэмээн хэлсэн үгийг санаж бүтээлийн төслөө хийж тайлбарлахыг зөвлөж байна.



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 113

Номгон

Аймгийн Хүүхдийн төлөө  
зөвлөлийг байгуулах тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16, 17 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хүүхдийн эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн даргаар аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-ыг сонгосугай.

2. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, хүүхэд, иргэдийн төлөөллийг оролцуулан баталгаажуулан, жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөтэйгээр ажиллах, хүүхдүүдийн хөгжил, оролцоо, авъяас чадварыг хөгжүүлэх, хамгаалах, хүүхдийн санал санаачлагыг дэмжих зорилго бүхий "Хүүхдийн төлөө сан"-г байгуулан, удирдлага, зохион байгуулалтаар ханган, сангийн хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт тусган, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд жилд нэг удаа тайлагнахыг аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн /Г.Батжаргал/ -д үүрэг болгссугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116783





БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 114

Номгон

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”  
ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, Компаний тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдааны 3/2 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Б.Батбаяр-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ш.Алтанбагана-Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн дарга

Б.Энхтүвшин-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ц.Дашцэрэн-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Э.Энхбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ж.Пүрэвсүрэн-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Д.Сайнжаргал-“Гал хонгор” ХХК-ний захирал


Д.Ширмэн-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

С.Цэцгээ-“Сүүн бэлэгдэл” ХХК-ний захирал, Монголын сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн гишүүн

2. Компаний дотоод журам бүтэц орон тоо, цалингийн санг хэлбогдох хууль тогтоомжийн дагуу баталж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан бүтэц орон тоо, цалинг олгож, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116133



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 115

Номгон

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг  
зохицуулах аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам, ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Уранчимэг/-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2012 оны 04, тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2013 оны 26, 137, 2015 оны 39 90, 135 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ АЙМГИЙН  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга -Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
- Нарийн бичгийн дарга -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн  
хэлтсийн дарга
- Гишүүдэд -Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
нарийн бичгийн дарга
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
ажлын албаны Зохион байгуулалтын хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын  
хэлтсийн дарга
  - Аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны  
шүүхийн Ерөнхий шүүгч /Зөвшилцсөнөөр/
  - Аймгийн Ерөнхий прокурор /Зөвшилцсөнөөр/
  - Аймгийн Цагдаагийн газрын дарга
  - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
  - Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга
  - Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
  - Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга
  - Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
  - Аймгийн Тагнуулын хэлтсийн дарга
  - Аймгийн Амьд хууль төрийн бус байгууллагын төлөөлөл
  - Аймгийн Өнөөгийн Баянхонгор сонины эрхлэгч
  - Иргэний төлөөлөл



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 116

Номгон

Аймгийн Аудитын газрын пургон маркийн  
автомашины шатсан шалтгааныг судлах, шалгах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.11 дэх заалт, Аудитын газраас ирүүлсэн автомашин актлуулах тухай хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Аудитын газрын пургон маркийн автомашины шатсан шалтгааныг судлах, бодит байдлыг шалгаж тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Баярсайхан-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Гишүүд: Т.Отгонбаатар-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Б.Нацагдорж-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Л.Доржханд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Ц.Байгальмаа-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн

2. Дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ажлын хэсэг /Н.Баярсайхан/-д даалгасугай.

2.1 Тухайн байгууллагын автомашин албан ажлаар явсан эсэхийг тогтоох

2.2 Шатсан автомашин нь одоо ямар байдалтай байгаа талаар бодит мэдээлэл дүгнэлтийг гаргах

2.3 Уг автомашиныг актлах эсвэл төлүүлэх талаар мэдээлэх

3. Ажлын хэсгийн дүгнэлт, мэдээллийг бэлтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд 2016 оны 11 дүгээр сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Баярсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



116117



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 117

Номгон

Аймгийн хэмжээнд 2016-2020 онд  
хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийг  
боловсруулж, батлуулах тухай

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх 19 хөтөлбөр, 7 төсөл батлуулж хэрэгжүүлэхээр тусгасан байна. Тухайлбал: 1 дүгээр бүлгийн 6 дахь хэсэгт “Шинэ хөдөө” хөтөлбөр, 7 дахь хэсэгт “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих” хөтөлбөр, 17 дахь хэсэгт “Сурагч бүр сурах бичигтэйгээ” хөтөлбөр, 22 дахь хэсэгт “Сайн багш” хөтөлбөр, 25 дахь хэсэгт “Хос бичигтэн аймаг” хөтөлбөр, 30 дахь хэсэгт “Элэг бүтэн-Баянхонгор” хөтөлбөр, 33 дахь хэсэгт “Агаар хөрсний бохирдлыг бууруулах” хөтөлбөр, 38 дахь хэсэгт “Эмч, эмнэлгийн ажилтан” хөтөлбөр, 59 дэх хэсэгт “Ахмадаа ачлая” хөтөлбөр, 2 дугаар бүлгийн 70 дахь хэсэгт “Хуримтлалтай хонгорчууд” төсөл, 74 дэх хэсэгт “Нэг уурхай-нэг үйлдвэр” хөтөлбөр, 79 дэх хэсэгт “24428 үйлдэр” төсөл, 85 дахь хэсэгт “Баруун зам” төсөл, 3 дугаар бүлгийн 92 дахь хэсэгт “Органик хүнс” төсөл, 95 дахь хэсэгт “Төрийн торгон сүрэг” төсөл, 103 дахь хэсэгт “Монгол мал” хөтөлбөр, 104 дэх хэсэгт “Эрүүл бүс-Эрүүл хүнс” төсөл, 105 дахь хэсэгт “Илгээлтийн эзэн” хөтөлбөр, 110 дахь хэсэгт “Ногоон Баянхонгор” хөтөлбөр, 4 дүгээр бүлгийн 123 дахь хэсэгт “Амины орон сууц” хөтөлбөр, 135 дахь хэсэгт “Ухаалаг Баянхонгор” хөтөлбөр, 136 дахь хэсэгт “Цахим монгол” хөтөлбөр, 140 дэх хэсэгт “Түрээсийн орон сууц” хөтөлбөр, 5 дугаар бүлгийн 144 дэх хэсэгт “Төрийн мэргэшсэн албан хаагч” хөтөлбөр, 149 дэх хэсэгт “Иргэний санал-Их хуралд” төсөл, 151 дэх хэсэгт “Амар тайван амьдрал” хөтөлбөр болно.

Хугацаа, хөрөнгө шаардах хөтөлбөр, төслүүдийг цаг алдалгүй боловсруулж эрэмбэ дарааг нь тогтоож, үйл ажиллагааны бусад ажил, арга хэмжээтэй уялдуулж, хөрөнгө санхүүгийн нөөцдөө тулгуурлан тооцоо судалгаа хийж батлуулах нь түүнийг хэрэгжүүлэх эхлэл болохыг ТЭМДЭГЛЭЭД

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалтуудыг тус гус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

116106

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөтөлбөр, төслүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэх зорилгоор дараах ажил, арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

1.1 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөтөлбөр, төслүүдийг боловсруулж, батлуулах, шаардагдах хөрөнгө төсвийг шийдвэрлүүлэх

1.2 Хөтөлбөр, төслийг боловсруулахад салбар хоорондын уялдааг сайжруулж, үе шаттай зохион байгуулах

1.3 Хөтөлбөр, төслүүдийг бэлтгэж боловсруулах ажлын хэсгүүдийг томилж, хэрэгжүүлж эхлэх хугацааг тогтоож, 2016 онд багтааж бодлогын баримт бичгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд урьдчилан хэлэлцүүлэх

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлогын хороод өөрийн чиг үүрэгт холбогдох хөтөлбөр, төслийг тухайн асуудлыг хариуцсан ажлын хэсэгтэй хамтран боловсруулахыг Бодлогын хороодын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР